



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!




№48 /492/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.03.22

Цаг үе, үйл явдал

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО





Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Канад Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе тэнгисийн цэргийн ахмад Андрью Кларкыг

Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаатай холбогдуулан Канад улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, хатагтай Катрин Э.Ивкоф болон бусад албаны хүмүүсийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.

Хошууч Ц.ДАВААДОРЖ



"ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ЁС ЗҮЙ" СЭДЭВТ СУРГАЛТ БОЛЛОО



Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-ийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсгийнхэн 3 дугаар сарын 21-ний өдөр "Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын ёс зүй" сэдэвт сургалтыг хурандаа Г.Ган-Эрдэнэ захирагчтай Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн 0151 дүгээр ангид зохион байгууллаа. Энэхүү сургалт нь цэргийн алба хаагчдад сэтгэл зүй, ёс суртахуун, харилцаа хандлага, төлөвшилд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, зорилготой бөгөөд Хилийн цэргийн ангид анхлан зохион байгуулагдсанаараа онцлог байв.

Сургалтын хүрээнд Батлан хамгаалахын

Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн хошууч А.Октябрь Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа болон "Иргэний зөвлөл"-өөс хийж хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулав. Тэр бээр "Зөв харилцаа-зөв хандлага" цахим нөлөөллийн аяны хүрээнд богино хэмжээний дүрс бичлэгийг үзүүлж, мөр зэрэгцэн алба хааж байгаа залуу офицер, ахлагч нарт хандлагаа өөрчилж, хариуцлагаа дээшлүүлэн ажиллахыг онцолсон юм.

Сургалтын төгсгөлд УБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Олон Улсын харилцаа нийгмийн удирдлагын тэнхимийн дэд профессор, багш П.Мөнхтөр, Иргэний зөвлөлийн гишүүн төрийн

шагналт яруу найрагч Д.Төрбат нараас бүрдсэн илтгэгчид Хилийн цэргийн алба хаагчийн ёс зүй, дархан хил дээр ажиллаж амьдрал үүрэг гүйцэтгэх сэтгэл зүй, манлайллын талаар сонирхолтой мэдээлэл хүргэж, харилцан яриа өрнүүллээ.

Мөн энэ үеэр ЦДБЭЧ-ын уран бүтээлчид урлагийн тоглолтоо өргөн барьсан ба Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч, хурандаа Г.Ган-Эрдэнэ эрдэмтэн багш, төрийн шагналт, ажлын хэсгийнхнийг сонирхолтой ярилцлага өрнүүлсэнд талархал илэрхийлж, энэхүү үнэтэй сургаалыг ажил, амьдралдаа мөрдлөг болгох нь алба хаагчдадаа уриаллаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,528	3,531
EUR	3,800	3,815
CNY	514	515
RUB	44.90	45.30
JPY	26.90	27.10
KRW	2.70	2.71

ЗУРХАЙ



2023.03.22 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

Наран ургах, шингэх:

06.52-19.06

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 682,715,331

Эдгэрсэн

Нийт: 655,686,679

Нас барсан

Нийт: 6,821,190

Цахим шууданд

ӨЛГИЙ ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ ТЭМЦЭЭНД УУЛЧИН ДАЙЧИД МАНЛАЙЛАВ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, Монгол цэргийн өдөр, Баруун хилийн тулгаралтын 75 жилийн ойг тохиолдуулан Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын цэргийн штабаас Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд “Марш тактикийн аварга тасаг”, “Цэрэгжлийн буудлага”-ын тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Цэрэгжлийн буудлагын тэмцээн Гар буу, АКМ, СВД-

ын төрлөөр явагдаж нийт 16 байгууллагын баг тамирчид цэц мэргэнээ сорин өрсөлдсөнөөс гар бууны төрөлд Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ мөнгөн медаль, орон сууц ашиглалтын офицер ахмад Д.Отгонтуяа алтан медаль, АКМ-ын төрөлд дэд ахлагч Б.Мөнгөнцэцэг алтан медаль хүртэж амжилттай оролцлоо.

Марш тактикийн тэмцээнд

нийт 10 байгууллагын 80 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцсоноос ахмад О.Мөргөн захирагчтай тасаг алтан медаль, дэслэгч Б.Түмэнсан захирагчтай тасаг мөнгөн медаль, анх удаа зохион байгуулагдсан эмэгтэй тасгийн тэмцээнд ахмад Д.Отгонтуяа захирагчтай тасаг алтан медаль хүртэж, байгууллагын дүнгээр тэргүүн байранд шалгарлаа.

Ахмад Ч.ДАЛАНТАЙ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 330 ДУГААР АНГИД...



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧИЛЛАА

“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жилийн ойд зориулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Энэ үеэр гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолт болон зэвсэглэл техникийн үзүүлэнг олон нийтийн хүртээл болгосны зэрэгцээ Батлан хамгаалах салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим цэргийн алба хаагчдыг шагнаж урамшууллаа.

Мөн энэ үеэр цогцолбор тэмцээнд тэргүүлсэн Зэвсэгт хүчний 330 дугаар анги, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газруудад тус тус шагналыг гардуулсан юм.

АХЛАХ АНГИЙН СУРАГЧИД ҮБХИС, ДХИС-ИУДААР ЗОЧИЛЛОО



Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох нөлөөллийн ажлын хүрээнд Ерөнхий боловсролын “Боловсрол”, “Оюуны Эрин”, “Гүн галуутай” цогцолбор сургуулиудын төгсөх ангийн сурагчдыг Үндэсний батлан хамгаалах их сургууль, Дотоод хэргийн их сургуультай “Танилцах

аялал”-ыг зохион байгууллаа. Уг “Танилцах аялал”-д Үндэсний батлан хамгаалах их сургууль, Дотоод хэргийн их сургуульд элсэн суралцах хүсэл, сонирхолтой 12 дугаар ангийн 45 сурагч оролцож сургуулийн үйл ажиллагаа, хичээлийн байр, танхим, номын сан, сургалтын материаллаг бааз, цэргийн зэвсэглэл техникийн үзэсгэлэн, “Тэмүүжин өрлөг” сургуулийн сурагчдын “Жагсаалын

үзүүлэх тоглолт”-ыг үзэж сонирхсоны зэрэгцээ ҮБХИС-ийн Сургалтын хэлтсийн дарга хурандаа Б.Батмөнх, ДХИС-ийн Сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн ахмад Д.Баттөр нараас тухайн сургуулийн элсэлтийн ерөнхий журмын талаар сонирхсон асуултаа асууж, тодруулсан юм.

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАГДСАН ДАЙЧДАА ЭРГЭЛЭЭ



“Монгол цэргийн өдөр”, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тохиолдуулан Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа З.Майдар нар Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Харуул үйлчилгээний ротод хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдаа эргэж алба хааж буй орчин нөхцөлтэй нь танилцлаа.

Энэ үеэр Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа З.Майдар нар түрүүч байлдагч нартай цэргийн албаны талаар халуун дулаан яриа өрнүүлсний зэрэгцээ цэргийн

эрдэмд шамдан суралцаж байгаад нь талархал илэрхийлж, гарын бэлэг гардуулсан юм.

Уулзалтын төгсгөлд дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан нар хамтын ажиллагааны талаар санал солилцон тус дүүргийн Батлан хамгаалах товчооны гишүүдийн сургалтыг тус сургуулийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулахаар тохиролцлоо.

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ



МАРШ-ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН АВАРГУУДЫГ ШАЛГАРУУЛЛАА

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жил, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан Дархан-Уул аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд спортын цогцолбор тэмцээнийг зохион байгууллаа.

Тухайлбал цогцолбор тэмцээний хүрээнд зохион байгуулсан “Марш тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах” тэмцээнд нийт 5 баг өрсөлдсөнөөс тэргүүн байрт Зэвсэгт хүчний 330 дугаар анги, дэд байрт Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, гутгаар байрт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 322 тусгай салбарын хамт олон тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагнал шилжин цомын эзэд болцгоосон юм.

Хошууч Э.ГАНЦООЖ

Дарга дэд хурандаа
САЙНБОЛДЫН
УУГАНБААР

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний
Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” редакц
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)